

БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРООНДЫН НӨХЦӨЛТ ЗЭЭЛИЙН
ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар цаашид "Гэрээлэгч талууд" гэх, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн дэмжих, Польш Улс, Монгол Улс хоорондын эдийн засгийн хамтын ажиллагааг гүнзгийрүүлэхийг эрмэлзэн дараах зүйлийг харилцан тохиролцов. Үүнд:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар Монгол Улсын хөдөө аж ахуй, дэд бүтэц, боловсролын шинэчлэл, байгаль орчныг хамгаалах салбарын төслийн санхүүжилтэд зориулж 50 сая (тавин сая) хүртэлх европийн зээлийг (цаашид "Зээл" гэх) Монгол Улсын Засгийн газарт олгоно. Энэхүү Зээлийг Польш Улсаас Монгол Улсад нийлүүлэх бараа, үйлчилгээний гэрзэний үнийн дунг 100 % (зуун хувь) санхүүжүүлэхэд ашиглана.

2 ДУГААР ЗҮЙЛ

1. Уг Хэлэлцээр болон Хэлэлцээрийн хүрээнд байгуулагдах тусгайлсан гэрээгээр санхүүжих бүх төслийд нь Эдийн Засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын нөхцөлт зээлийн журам, Албан ёсны дэмжлэг бүхий экспортын зээлийн Зохицуулалтад тодорхойлсон болон ЭЗХАХБ-ын холбогдох бусад баримт бичигтэй нийцсэн байна.
2. Монгол Улсын Засгийн газар ЭЗХАХБ-ын нөхцөлт зээлийн холбогдох дүрэм журмын дагуу зээлийн хөрөнгийг ашиглах, Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газарт ЭЗХАХБ-ын хөнгөллөлтэй зээлийн журмын хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэхэд бэлэн болохыг баталгаажуулав.
3. Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар нь энэхүү зүйлийн 1 дүгээр хэсэгт дурдсан зохицуулалтын дагуу тус Хэлэлцээр, төслийд болон Зээлийн хүрээнд санхүүжих бүх гэрээг ЭЗХАХБ-д мэдэгдэнэ. ЭЗХАХБ-д мэдэгдсэн төслийд эсхүл тусгайлсан гэрээнүүдийг үл зөвшөөрсэн бол энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасан зохицуулалтын дагуу тусгайлсан гэрээ, төслийг Гэрээлэгч талууд харилцан тохирсон эсэхээс үл хамааран гэрээг энэхүү Хэлэлцээрийн хүрээнд санхүүжүүлэхгүй.

- Гэрээлэгч талууд нь өөрийн улсын гүйцэтгэгчдэд ЭЗХАХБЫН журам, нехцэлт зээлийн зохицуулалтын талаар мэдээлнэ.

З ДУГААР ЗҮЙЛ

- Тус Зээлээр санхүүжих төслийг хэрэгжүүлэх гэрээнүүд нь Хэлэлцээрийн заалтын дагуу байгуулагдана. Гэрээнд тусгагдах талуудын экспортын бичиг баримт, ялангуяа нэхэмжлах, гэрээнд "Бугд Найрамдах Польш Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар хооронд оны ... сарын өдөр байгуулсан нехцэлт зээлийн хэлэлцээрийн дагуу" гэсэн заалтыг тусгасан байна.
- Хэлэлцээрийн 1 дүгээр зүйлд дурдсан гэрээнүүдийг Монголын импортлогч болон Бугд Найрамдах Польш Улсад байршилтай үйлдвэрлэгч (цаашид "Польшийн гүйцэтгэгч" гэх) нар энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дотор байгуулна.
- Зээлээр санхүүжих төслийг хэрэгжүүлэх Польшийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад Монгол Улсын худалдан авах ажиллагааны холбогдох хууль, журмыг мөрдлөг болгоно.
- Энэ Хэлэлцээрийн дагуу санхүүжүүлэх гэрээнүүд болон төслийд нь Гэрээлэгч талуудын дотоодын хуулиар баталгаажсан байна.
- Тус Хэлэлцээрийн хүрээнд байгуулагдах гэрээнүүдийг Гэрээлэгч талууд дараах журмын дагуу батална.Үүнд:
 - Монгол Улсын Сангийн яам нь тухайн гэрээ нь Монгол Улсын холбогдох эрх бүхий байгууллагаар батлагдсан тухай Бугд Найрамдах Польш Улсын Сангийн яаманд бичгээр мэдэгдэнэ;
 - үүний дараа Бугд Найрамдах Польш Улсын Сангийн яам нь Монгол Улсын Сангийн яаманд тухайн гэрээг зөвшөөрсөн талаар бичгээр мэдэгдэнэ;
 - Бугд Найрамдах Польш Улсын Сангийн яам Монгол Улсын Сангийн яаманд гэрээний зөвшөөрлийг бичгээр хургуулсан өдрөөс хойш 15 хоногийн дараа гэрээ хүчин төгөлдөр болно;
 - гэрээг баталгаажуулах хугацаа Гэрээлэгч тал бүрт 60 хоногоос хэтрэхгүй байна.
- Гэрээлэгч талууд гэрээг баталгаажуулах зөвшөөрлийг гэрээний талуудын санхүүгийн байдал, татвар, хураамжийн төлөлт, олон улсын шилжүүлэг амжилттай хийж байсан баримт болон энэхүү хэлэлцээр ба ЭЗХАБЫН дүрэм журмыг дагаж мөрдөх тухай мэдэгдлийг харгалзах тухай нэмэлт нехцэлүүд тавьж болно.

4 ДҮГЭР ЗҮЙЛ

1. Энэхүү хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээнд заасан Польшийн гүйцэтгэгчийн төлбөрийг Хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрыг төлөөлж Эдийн засгийн хөгжил, сангийн сайд Зээлийн үйлчилгээг үзүүлэх эрх бүхий банкны агентлагаар гэрээнд заасан нөхцлийн дагуу Польш Улсын төсвийн хөрөнгөөс Польш злотоор олгоно.
2. Бүх үнийг олон улсын зах зээлийн үнийн жишгээр тогтоож, гэрээний үнийн дүн еврогоор илэрхийлэгдсэн байна.
3. Энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Бүгд Найрамдах Польш Улсаас Монгол Улсад экспортолсон бүх бараа бүтээгдэхүүнийг Бүгд Найрамдах Польш Улсын Эдийн засгийн хөгжил, сангийн сайдын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр өөр улсад дахин экспортлохыг хориглоно.
4. Тус Хэлэлцээрийн хүрээнд санхүүжих гэрээний Польшийн гарал үүсэл бүхий бараа, үйлчилгээний өртөг гэрээний үнийн дүнгийн 60% (жаран хувь)-иас доошгүй байна. Гэрээлэгч талууд тус шаардлагыг хангасан тухай нэмэлт мэдээлэл, холбогдох баримт бичгийн мэдүүлэг, жишээ нь: гарал үүслийн гэрчилгээ заргийг экспортлогчоос шаардаж болно.

5 ДУГААР ЗҮЙЛ

Зээлийн ашиглалт гарсан огноо нь Польшийн гүйцэтгэгчид гэрээний дагуу төлбөр төлсөн өдөр байна. Төлбөрийг Польшийн гүйцэтгэгчид зөвхөн тус Хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт заасны дагуу томилогдсон Господарства Кражовего Банк, тус Хэлэлцээрийн 10 дугаар зүйлийн 1 дүгээр хэсэгт заасны дагуу Зээлийн үйлчилгээ үзүүлэхээр Монголын Засгийн Газраас томилогдсон банкны төлбөрийн баталгаажуулалтыг хүлээн авсны дараа хийж гүйцэтгэнэ.

6 ДУГААР ЗҮЙЛ

1. Монгол Улсын Засгийн газар нь Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газарт Зээлийн ашиглалт бурийн зргэн төлөлтийг үндсэн талберөөс чөлөөлөгдхөх 5 жилийн хугацаа дууссаны дараагаар 56 хэсэгчлэн, жилд 2 удаа 4 дүгээр сарын 15-ны өдөр, 10 дугаар сарын 15-ны өдруүдэд тэнцүү хэмжээгээр ашиглалт гарсан өдрөөс тооцож еврогоор хийнэ.
2. Зээлийн зргэн төлөлтийн эхний хэсэгчилсэн төлбөр нь зээлийн ашиглалт гарснаас хойшхи үндсэн талберөөс чөлөөлөгдхөх 5 жилийн хугацаа дууссаны дараах төлбөр төлөх эхний өдөр байна.

7 ДУГААР ЗҮЙЛ

1. Тус Хэлэлцээрийн 5 дугаар зүйлд дурдагдсан ашиглагдсан Зээл нь жилийн 0.15% (тэг зууны араван таван хувь)-ийн хүүтэй байна. Тус зээлийн хүү нь Хэлэлцээрийн 5 дугаар зүйлд заасан өдрөөс эхлэн тооцогдоно.
2. Зээлийн хүүг зээлийн ашиглалт гарсан өдрөөс хойш хагас жил бур хэсэгчлэн, жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны өдөр, 10 дугаар сарын 15-ны өдрийдэд европогоор тооцож төлнэ.
3. Зээлийн хүүгийн эхний төлбөрийг зээлийн ашиглалт гарснаас хойш зээлийн хүүг тооцох эхний өдөр төлнэ.
4. Зээлийн хүүг тооцоходо нэг жилийн хугацааг тухайн жилийн хоногийн тоог харгалзан үзэж 360 хоногоор тооцно ($365[366]/360$).
5. Монгол Улсын Засгийн газар Хэлэлцээрт товлогдсон хугацаанд аливаа төлбөрийг хийж чадаагүй тохиолдолд телегдсөгүй дунд 1 дүгээр хэсэгт тодорхойлогдсон хүүгээс гадна 1.5% (нэг аравны таван хувь)-ийн торгуулийн хүү тооцогдоно. Торгуулийн хүүг төлбөр хийх өдрөөс эхлэн төлбөр хийгдсэн өдөр хүртэл тооцно.
6. Зээлийн төлбөр хоцрох болон эргэн төлелтийн хэмжээ нь телегдех ёстой хэмжээнд хурэхгүй тохиолдолд нийт төлбөрийг эхлээд төлбөр төлөх өдрөөс хойш гарсан торгуулийн хүүг төлөхөд, дараа нь төлбөр төлөх өдөр хүртэлх хүүг төлөхөд, үүний дараагаар үндсэн дүнг төлөх журмаар ашиглана.

8 ДУГААР ЗҮЙЛ

Тус Хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж буй гэрээний дагуу Польшийн гүйцэтгэгчид төлөх төлбөрийг тус Хэлэлцээр дэх гэрээ хэрэгжүүлж дуусах хүртэл хүчинтэй байх нэхцэл заалтын дагуу хийгдэх бөгөөд тус гэрээ хүчин тэгэлдээр болсноос хойш 5 жилийн дотор хийж гүйцэтгэнэ.

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Тус Хэлэлцээрийн хүрээнд төлөх аливаа төлбөрийг гүйцэтгэх өдөр нь төлбөр телегдех улсад ажлын бус өдөр таарвал анхны өгөгдсөн төлбөр төлөх өдрийн дараагийн ажлын өдрөөр тооцож төлнэ. Хэлэлцээрт заасан ажлын өдөр гэдэг нь дурдсан орны банкууд дотоод ба гадаадын гүйлгээ, валютын арилжаа гүйцэтгэдэг өдрийг хэлнэ.

10 ДУГААР ЗҮЙЛ

1. Тус Хэлэлцээрийн дагуу Зээлийн ашиглалтыг бүртгэх болон зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрүүдийг бүртгэх зорилгоср Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрыг төлөөлж буй Господарства Кражовего Банк Монгол Улсын Засгийн газрын томилсон банкны нэр дээр "Монгол Улсын Засгийн газрын нөхцөлт зээл" гэсэн тодотголтой Еврогийн данс нээнэ. Монгол Улсын Засгийн газрын томилсон банк Господарства Кражовего Банкны нэр бүхий холбогдох дансыг өөрийн банкинд нээнэ. Тус Зээлийн данснууд аливаа шимтгэлгүй байна.
2. Господарства Кражовего Банк болон Зээлийн үйлчилгээ үзүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын томилсон банк нь тус Хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай банкны зохицуулалтуудыг тус хэлэлцээр хүчин төгөлдөр болсны дараа аль болох хурдан хугацаанд бий болгоно.

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Тус Хэлэлцээрийн хүрээнд байгуулагдсан гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах аливаа татвар, хураамж, шимтгал болон бусад төлбөрийг Гэрээлэгч талууд тус тусын улс орондоо төлөх ба тус Зээлийн хөрөнгөөс санхүүжүүлэхгүй.
2. Энэхүү Хэлэлцээртэй ямар нэгэн байдлаар холбогдох эргэн төлөлтийн хүрээнд гарч болох аливаа банкны шимтгал, түүнчлэн бусад төлбөрийг гэрээний талууд өөрийн улсад тус Зээлээс хамааралгүйгээр төлнэ.
3. Тус Хэлэлцээрт тусгагдсан зээлийн үндсэн төлбер, хүүгийн бүх төлбөрийг Монгол Улсын ногдуулах аливаа татвар, хураамжаас чөлөөлнэ.

12 ДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх ба тайлбарлахад үүсэн маргааныг Гэрээлэгч талуудын эрх бүхий байгууллагууд шууд хэлэлцээ хийх замаар шийдвэрлэнэ.

13 ДУГААР ЗҮЙЛ

Энэ Хэлэлцээрт оруулах аливаа өөрчлөлтийг Хавсралт хэлбэрээр бичгээр оруулах бөгөөд Хэлэлцээрийн салшгүй хэсэг байна. Хавсралт нь энэхүү Хэлэлцээрийн 15 дугаар зүйлийн дагуу хүчин төгөлдөр болно.

14 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Тус зээлийн хэлэлцээртэй холбостой бүх харилцаа ба баримт бичгийг англи хэл дээр үйлдэнэ.

15 ДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээр Гэрээлэгч талуудын дотоодын хууль тогтоомжийн дагуу батлагдах бөгөөд энэ тухайгаа Нот бичиг солилцож баталгаажуулна. Хэлэлцээр нь талуудын Нот бичгийн сүүлийн өдрөөр хүчин төгөлдөр болно. Тус Хэлэлцээр нь Гэрээлэгч талууд Хэлэлцээрт заасан бүх үүргээ биелүүлтэл хүчинтэй байна.

2017... оны 06. сарын 09 өдөр ...Хэлэлцээр... хотноо монгол, англи, польш хэлээр тус бүр 2 эх хувь байгуулсан бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Эх бичвэрүүдийг тайлбарлахад зоруу гарсан тохиолдолд англи хэлээрх эхийг баримтална.

Монгол Улсын

Засгийн газрыг төлөөлж

Бүгд Найрамдах Польш Улсын

Засгийн газрыг төлөөлж